

ДОРНОД АЙМАГ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 10

Хэрлэн сум

Орон тооны ажилтан томилох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8, 15.20 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төлөөлөн удирдах зөвлөлийн орон тооны ажилтан нарийн бичгийн даргаар М.Цэрэндавааг 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс томилсугай.

2. Нарийн бичгийн дарга У.Насантогтохоос М.Цэрэндаваад ажил хүлээлцүүлэхийг гишүүн Х.Баатарсүх, Б.Ганболд нарт үүрэг болгосугай.

3. М.Цэрэндаваагийн албан тушаалын үндсэн цалинг төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээний ТҮ-4 буюу 1.105.000 төгрөгөөр шинэчлэн тогтоож, төрийн алба хаасан хугацааны болон орон нутгийн нэмэгдлийг холбогдох журамд заасны дагуу олгосугай.

4. М.Цэрэндаваагийн цалинг холбогдох хууль, журмын дагуу 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс тооцож олгохыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал /Д.Должин/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА МӨНХБААТАР

